

БАЙГАЛЬ БОЛОН УРЛАГИЙН ТАЛААРХ Ф.ШЕЛЛИНГИЙН ФИЛОСОФИЙН ҮЗЭЛ

Л. Батнасан - МУИС–ийн философийн тэнхмийн докторант

Түлхүүр үг: Байгалийн философи, домог зүй, урлагийн философи

Товч утга: Германы идеалист философич Фридрих Вильгелм Иозеф Шеллинг бол нийгмийн сэтгэлгээний түүхэнд германы романтизмын үзэл сурталч, трансценденталь философийг үүсгэн бүтээгч, урлагийн философид тухайн үеийнхнээсээ илүү анхаарсан гэдгээрээ онцлогтой. Тэрээр философийн шийдэх ёстой асуудалд илүү анхаарч байсан ба түүнийхээр ухамсраас ангид орших байгаль ухамсар үүсэхэд хэрхэн нөлөөлж мөн оршин буй утгат чанараараа субъект болдог ухамсар яагаад объект болов, оюун ухаан, байгаль хоёр, субъект, объект хоёр хэрхэн хосолдог болох зэрэг асуудалд философи л хариулт өгөх хэрэгтэй гэж үзэж байв. Энэ нь Шеллингийг объект, субъектийн аль алиных нь давуу болон сул талыг өөртөө анхаарлын тэмдэг болгон тавьж эцэстээ адилтгалын үзэл санааг дэвшүүлэхэд хүргэсэн юм. Түүний үзэл санаа ерөнхийдөө: Байгалийн философи, Домгийн философи, Урлагийн философиор зангилагддаг.

Ф.Шеллинг судалгааныхаа эхэн үед байгалийн тухай асуудлыг авч үзэж 1800 онд хэвлүүлсэн “Трансценденталь идеализмын тогтолцоо” бүтээлдээ Фихтегийн субъектив идеализмыг өөрийн объектив идеализмтай харьцуулан авч үзсэн байдаг.

Байгалийг тэрээр хөгжил дэвшлийн замаар, тийн өөртөө ухамсрын элемент хуримтлуулсан хөгжил нь өгсөх замаар ухамсарт шилжинэ гэж үзэж байв. Түүний философийн гол цөм нь нэгдмэл адилслын тухай асуудал. Нэг ёсондоо байгаль хийгээд ухамсар дахь эсрэг тэсрэгийн диалектикийн асуудлыг чухалчилж байв. Объект, субъект, байгалийн ба байгалийн бус хэмээх энэ бүх эргэцүүллүүд түүнийг хоёр дахь байгалийн үзэл санаанд хөтлөн улмаар байгалийн бүтээл өөрийн жамаараа тодорхойлогддог байхад хүний бүтээсэн бүтээл урлагийн үйлдвэрлэл буюу уран сайхны бүтээлүүд болж түгдэг хэмээх үзэл санаанд хүргэсэн байдаг.

“... Ф. Шеллинг санаа, байгаль хоёрыг адилтгаж, ертөнцийн бүхий л юмс “Санаа”-гаар нэвчсэн байдаг тухай сургаалийг шинжлэх ухаан болон хүний үйл ажиллагааны бүхий л төрлүүд урлагийн бүтээл болж хувирах шинэ домог зүйн нийлэгийн тухай эргэцүүллийнхээ үндэс болгосон юм”⁵⁴.

Үүнээсээ үүдэн тэрбээр домгийн талаар бичсэн байдаг. Ф.Шеллинг бичихдээ: “Домог зүйг ард түмний гүнд нэвчин оруулахад зайлшгүй хэрэгтэй хүмүүсийн сэтгэлгээн дэх бодит зүйлийг домог зүйд буй болгож, түүнийг бүтээхгүйгээр, түүний яруу сайхны ашиглалт боломжгүй. Энэ бүгд нь нэг хүний боломжоос төдийгүй энэ зорилгод нэгдсэн олон хүний боломжоос ч давсан зүйл юм”⁵⁵ гэжээ.

Түүнийхээр домог зүй нь нийгмийн ухамсрын хөгжил дэх зүй тогтолт үе шат болохоос өөр юу ч биш юм. Домог зүй нь нийгмийн аль нэгэн цогц субъект (овог, аймаг, ард түмэн, үндэстэн) өөрийн ахуйг, ертөнцийн тогтолцоонд хүний

⁵⁴ Билгүүдэй Ш. Өрнө дахины уран сайхны шүүмжлэлт сэтгэлгээний тойм. УБ.: 2007, 73 дахь тал

⁵⁵ Шеллинг Ф. Собр. Соч.: В 2 т. - Т.1. - М., 1976. С - 31-32

эзлэх байр суурийг ухамсарлах хэрэгцээ буй болсон үед л үүсдэг байна. Тэрээр энэ талаар Шеллинг “домогу зүй нь ард түмэн-бодгаль хүний ухамсар байдлаар ард түмэнтэй хамт үүссэн”⁵⁶ гэж тодорхойлсон нь бий. Ийнхүү тэрээр домог зүй болон ахуйн холбоог онцлон тэмдэглэсэн байдаг.

Ф.Шеллингийн баталснаар домог зүйн үндэс нь “Алтан үе”-ийн түрүү үеийн монотеизмтэй холбогджээ. Энэ нь далдыг харахуйгаар дамжсан монотеизм байв. Тэр үед “Хүн төрөлхтөн мэдэхгүй юмандаа мөргөн биширдэг байж”⁵⁷. Тэрхүү “Шидэт домог шашныг урьдчилан төсөөлсөн... Энэ бол байгалийн шашин, далдыг мэдэж, урьдчилан хэлэх шашныг талархсан жам ёсны шашин”⁵⁸. Ийм л үүргээрээ шидэт домог урлагтай холбогдож эхэлсэн.

Тухайн үеийн Европт германы сонгодог философичид үзэл санааныхаа цараар газар авч, тэр дундаас урлагийн асуудлыг философитой харьцуулан дагнан судалснаараа Шеллинг яах аргагүй ялгарч байв. Шеллингийн үзсэнээр, философи болон шинжлэх ухаан нь юун түрүүнд гоо сайхны үнэлэмжийн ертөнц юм. “Нийгмийн тухай философид соёлын философи хэмээх салбар бий болсон нь соёлын үзэгдлүүдийг философийн үүднээс бясалгасны үр дүн мөн төдийгүй соёл судлалын бүх салбарын ололтыг нэгтгэн дүгнэсний үр дүн”⁵⁹ ажээ.

“Ф.Шеллинг шинжлэх ухаан, урлаг хоёрыг харьцуулаад урлагийг илүүтэйд үзжээ. Яагаад гэвэл түүнийхээр урлагт байдаг шиг юмсын мөн чанарт нэвтрэх боломж шинжлэх ухаанд байдаггүй байна. Мөн урлаг философи хоёрын харьцааны тухай асуудлыг Шеллинг бас шийдвэрлэжээ. Урлаг нь философийг бодвол баялаг бөгөөд тодорхой, бүхэл бүтэн чанартай, бас хүртээмжтэй”⁶⁰ гэж үзжээ.

Урлаг хүнийг дээд танин мэдэхүйд хүрэхэд хамгийн дөт зам гэж үзсэн юм. Энэ нь зөвхөн уран сайхны бүтээлд адилслын зарчим биеллээ олдог, объектив ба субъектив зүйлийн туйлын зохиролд хүрдэг, “Бидэнд орших эцсийн гүн гүнзгий зөрчлүүд” шийдвэрлэгддэгтэй холбоотой аж.

Ф.Шеллинг урлагийг философийн эх сурвалж төдийгүй зорилго нь гэж үзсэн байдаг. Мөн түүнд философи юмс, үзэгдэл түүний дотор урлагийн мөн чанарт хүрэх боломжийг олгоно гэсэн үзэл ч бий.

Түүнчлэн “Урлагийн дотор гүнд шинжлэх ухааны утгаар философи ойлголтоос гүнзгий өөр юу ч нэвтэрч чадахгүй, ... философич бүр уран бүтээлчээс нь ч илүү урлагийн өөрийнх нь мөн чанарыг тодорхой хардаг”⁶¹ гэсэн санаа бий.

⁵⁶ Шеллинг Ф. Собр. Соч.: В 2 т. – Т.1. – М., 1976. С – 255

⁵⁷ Там же. С – 317

⁵⁸ Там же. С – 368

⁵⁹ Гомбосүрэн Ц. Нийгмийн тухай философи интеграль /нэгтгэгч/ хувилбарыг боловсруулах эхлэл. –УБ. 1999. 31 дэх тал.

⁶⁰ Гомбосүрэн Ц., Дорждагва Т. Өрнөдийн соёлын философи. – УБ-Хөх хот. 2010. 152 дахь тал

⁶¹ Шеллинг Ф. Собр. Соч. : В 2т. – Т. 1. – М., 1976. С – 52

Энэ нь үндсэндээ урлагийг танин мэдэх туйлын арга бол философийн арга гэж дүгнэн үзэхэд хүргэж байна. Түүнд мөн урлаг бол юмсын биш үзэл санааны тусгал гэсэн маш чухал санаа бий. Тэрээр байгалийг болон өөрөө өөрийгөө танихад урлагийн үйлдвэрлэл буюу уран сайхны соёл ихэд чухал болох талаар авч үзсэн байдаг.

“Урлаг бол бодит байдлыг гоо сайхны талаар эзэмших дээд хэлбэр, түүний мөн чанар, үүргийг судлах чухал хэрэглэгдэхүүн болдог байна... мөн уран сайхны дүрд шингэсэн бодит байдлын үзэл санаа сэтгэл хөдлөлийн дүр”⁶² болж таарч байна. Ф.Шеллинг энэ талаар болон үнэн хийгээд сайн, сайхны зохиролт нэгдлийн тухай асуудлыг анхлан хөндөгчийн нэг болж өөрийн шийдлийг өгчээ.

Соёлын ертөнцийг тэрээр “Олон юманд холбогдоод байдаггүй бурхан тэнгэрлэг зүйл хууль тогтоомж, ноёрхол, сүсэг бишрэлээр дамжин илрэхэд олон түмэн дахиад л үндэс нь болдог хүний ертөнц мөн”⁶³, харин байгаль нь “хүнд бурхан тэнгэрлэг зүйлийг бүрдүүлж, бусад бүх бүтээгдэхүүндээ зөвхөн материал болон үнэн мөн чанараа үзүүлэх зайлшгүй үндсийг нь буй болгодог”⁶⁴ гэж бичжээ.

Тэрээр “Философи агуу их өндөрт хүрдэг. Гэхдээ энэ өндөрт философи нь хүний зөвхөн хэсэгхэнийг нь авч сонирхоно. Урлаг бол бүхэллэг хүнд өөр өндөрлөгт, эрхэм дээдийг танин мэдэхүйд хүрэх боломжийг олгодог. Үүнд л урлагийн өвөрмөц онцлог болон түүнд зуршмал бүх сэтгэл татам чанар үндэслэгдэнэ”⁶⁵ гэж бичжээ.

Урлагийн онцгой байр суурийг Ф.Шеллинг ийнхүү үндэслээд философийн гол зорилт нь урлагийн мөн чанарыг ойлгох, гоо сайхны бясалгал хийгээд сайхнаар цэнгэхүйн нууцыг илрүүлэх явдал гэж нотолжээ. Бүх шинжлэх ухаан, тэрчлэн философи, өөрийн анхдагч үндсэндээ эргэж ирэх үест “Анх тэднийг үдэн гаргасан бүхнийг багтаагч утга зохиолын орчил руу”⁶⁶ зайлшгүй эргэж ирнэ гэж Ф.Шеллинг тунхагласан байна. Урлагийг ийнхүү тайлбарласан нь Ф.Шеллингид германы романтизмын үзэл санаа хүчтэй нөлөөлсөний үр дүн байж болох юм.

Тэрээр бичихдээ: “Урлагийн дотор гүнд шинжлэх ухааны утгаар философи ойлголтоос гүнзгий өөр юу ч нэвтэрч чадахгүй, ... философич бүр уран бүтээлчээс нь ч илүү урлагийн өөрийнх нь мөн чанарыг тодорхой хардаг”⁶⁷ гэжээ. Ф.Шеллинг: “Үнэндээ урлагийн нэгдмэл бүтээл л оршин байдаг, бүгдээрээ албагүй ч урлагийн бүтээл хичнээн тоо ширхэгтэй байсан ч бай өөрийн анхны дүр төрхөөрөө оршихын тулд цорын ганц урлагийн бүтээл л үлддэг”⁶⁸ гэж үзсэн байна.

⁶² Гутнер Л. М. Философи. /Орч. Н. Энхцогт., Ц. Алтантуяа/. 33-34 дэх тал.

⁶³ Шеллинг Ф. Собр. Соч.: В 2 т. - Т.1. - М., 1976. С - 67

⁶⁴ Там же. С - 67

⁶⁵ Шеллинг Ф. Система трансцендентального идеализма. - Л., 1936. С - 396

⁶⁶ Шеллинг Ф. Система трансцендентального идеализма. - Л., 1936. С - 394

⁶⁷ Шеллинг Ф. Собр. Соч.: В 2 т. - Т.1. - М., 1976. С - 52

⁶⁸ Шеллинг Ф. Система трансцендентального идеализма. - Л., 1966. С - 392

Ф.Шеллинг урлагийг байгалийн тусгал бус гэж үзсэн байна. Хамгийн төгс урлагийн бүтээл бол байгалийн бүтээсэн зүйлийн яг таг хуулбар байх ёстой гэж үздэг хүн бол маш эндүү хүн гэж нотолжээ. Хэрэв урлаг тусгадаг бол өөрчлөгддөггүй мөнх юм, өөрөөр хэлбэл өнгөц, гадна байдаггүй, гоо сайхны бясалгалын явцад нээгдэн илэрч байх ёстой тийм гол чухал талууд л зөвхөн урлагт тусгагдана. Өөрөөр хэлбэл урлаг бол үзэл санааны тусгал болохоос юмсынх биш. Энэ баримтын улмаас урлаг төгс төгөлдрийн туйлд илүү ойр. Түүгээр барахгүй урлаг нь “төгс туйлын бүх хуваагдашгүй мөн чанарыг”⁶⁹ өөртөө багтаадаг гэж Ф. Шеллинг нотолдог. Ийнхүү тэрээр бүхий л зүйлсийн утга учир, объектив, субъектив зүйлсийн адилсал агаад ондоошлын учгийг урлагаас хайх хэрэгтэй, урлагт тийм хүч бий болох талаар нухацтай авч үзжээ.

SUMMARY

Fredric Wilhelm Joseph Shelling German idealist philosopher is specific over German romanticism ideology organizing system of transcendental philosophy, and cared more than others on art philosophy. In history of social thought. Generally in his opinion: Natural philosophy, Mythology, Art philosophy. He studied moral about nature in the beginning of study, so published “System of transcendental idealism” which tells combination of subjective idealism of Fichte his own objective idealism. Pondering over object and subject, natural and non natural led him into second natural opinion, so he reached ideas that natural creatures are determined in natural law, but human creatures are distributed as art manufacturer, or artistic creatures.

According to Shelling, mythology is regular step over development of social awareness, alone it is nothing. Mythology is some social complete subject (tribe, province, people, ethnic group) it originated, when there is necessary of understanding own existence and human position in universal system. Shelling wrote “Mythology was originated with people as people’s individual awareness”. German classical philosophers are monopolized as their range of ideas at that particular time in Europe. From all of them Shelling was distinguished as studying and comparing art with philosophy continually. After comparison of art and science, he estimated that art has magic charm to penetrate into things essence, but science has shortage of that and art is more sufficiency than philosophy. He used to teach that art is the easiest way to make human reach in upper Shelling estimated that art is not only original source of philosophy, it is a goal.

Ном зүй

1. Билгүүдэй Ш. Өрнө дахины уран сайхны шүүмжлэлт сэтгэлгээний тойм. УБ., 2007
2. Шеллинг Ф. Собр. Соч.: В 2 т. – Т.1. – М., 1976.
3. Гомбосүрэн Ц.Нийгмийн тухай философи интеграль /нэгтгэгч/ хувилбарыг боловсруулах эхлэл. –УБ. 1999.
4. Гомбосүрэн Ц., Дорждагва Т. Өрнөдийн соёлын философи. – УБ-Хөх хот. 2010.
5. Шеллинг Ф. Собр. Соч. : В 2т. – Т. 1. – М., 1976. С – 52
6. Гутнер Л. М. Философи. /Орч. Н. Энхцогт., Ц. Алтантуяа/.
7. Шеллинг Ф. Система трансцендентального идеализма. – Л., 1936.
8. Шеллинг Ф. Философия искусства. – М., 1996. С – 66

⁶⁹ Шеллинг Ф. Философия искусства. - М., 1996. С - 66